



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 114

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн тоо тогтоох тухай

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны 2024 оны 09 дүгээр Тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг дэвсгэрт 2024 онд сонгон шалгаруулалтаар олгох арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн аймаг тус бүрд 1 /нэг/ байхаар тогтоосугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР